



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

АЙМАГ^Г (НИЙСЛЭЛ) ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТЭС (ГАЗАР)-ИЙН
ДАРГА НАРТ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2021.12.07 № 3/8163
танай -ны № -т

Г Т

Шийдвэр хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны “Жишиг үнийн жагсаалт шинэчлэн батлах тухай” А/507, А/112 дугаар хамтарсан тушаал батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар 01-ний өдрийн “Заавар батлах тухай” А/162 тоот тушаалаар “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний төлбөр олгоход баримтлах заавар”-ыг шинэчлэн баталсныг хүргүүлж байна.

Иймд уг зааврын хэрэгжилтийг зохион байгуулж холбогдох байцаагчдыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана уу.

Хавсралт Ж хуудастай.

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ
СУДАЛГААНЫ ГАЗРЫН
ДАРГА Ц.ГАНЦЭЦЭГ





НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 01 өдөр

Дугаар A/162

Улаанбаатар хот

Г Заавар батлах тухай Т

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны “Жишиг үнэ шинэчлэн батлах тухай” А/507, А/112 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний төлбөр олгоход баримтлах заавар”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

Хоёр. Зааврыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /газар/-ийн дарга нарт, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханганд ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг), холбогдох програм хангамжид өөрчлөлт оруулж, нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэхийг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар), зааврын хэрэгжилтэд хяналт тавихыг Хяналт, шалгалтын газар (Д.Ганзориг), Дотоод аудит, мониторингийн газар (Б.Ганхуяг), Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс (П.Мөнхтулга)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэд дарга (Г.Саран)-д даалгасугай.






НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ УЛМААС
ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРАА АЛДСАН ДААТГУУЛАГЧИД ХИЙМЭЛ ЭРХТЭН, ЗАСАЛ
ЭМЧИЛГЭЭ /ПРОТЕЗ, ОРТОПЕД/-НИЙ ТӨЛБӨР ОЛГОХОД БАРИМТЛАХ ЗААВАР

Баримт бичгийн заавар:

Баталсан:	Нийгмийн даатгалын ерөнхий газар газрын дарга		D.Zorigt
Хянасан:	Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга		C.Ganzeeg
Болорвсруулсан:	Бодлогын хэрэгжилт судалгааны газрын мэргэжилтэн		T.Uanga

Эх хувь	
Хяналттай хувь	
Хуулбар ба хяналттай хувь	
Хүчингүй хувь	

Дардас




НДЕГ "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ /протез, ортопед/-ний төлбөр олгоход баримтлах заавар"

Баримт бичгийн үзүүлэлт

Журмын хариуцагч	Тушаалын дугаар	Батлагдсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
НХХЯ, ЭМЯ	№ 74/116	2003.05.12	2003.05.12	3

Өөрчлөлтийн тухай тэмдэглэл

Хувилбар	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
Хувилбар 1			
Хувилбар 2			
Хувилбар 3			
Хувилбар 4			





НДЕГ "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ /протез/-ний төлбөр олгоход баримтлах заавар"

АГУУЛГА

1. Нийтлэг үндэслэл
2. Монгол Улсад хийлгэсэн протез, ортопедийн төлбөр олгох
3. Гадаад улсад хийлгэсэн протез, ортопедийн төлбөр олгох
4. Хяналт
5. Хариуцлага





НДЕГ "ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ УЛМААС ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРАА АЛДСАН ДААТГУУЛАГЧИД ХИЙМЭЛ ЭРХТЭН, ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭ /ПРОТЕЗ, ОРТОПЕД/-НИЙ ТӨЛБӨР ОЛГОХОД БАРИМТЛАХ ЗААВАР"

Нийгмийн даатгалын өрөнхий газрын даргын
2021 оны 11 дугаар сарын 01-ны өдрийн
A/16.1 тоот тушаалын хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ УЛМААС ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРАА АЛДСАН ДААТГУУЛАГЧИД ХИЙМЭЛ ЭРХТЭН, ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭ /ПРОТЕЗ, ОРТОПЕД/-НИЙ ТӨЛБӨР ОЛГОХОД БАРИМТЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ (цаашид "протез, ортопед" гэх)-ний төлбөр олгоход энэхүү зааврыг баримтална.

1.2 Даатгуулагчид протез, ортопедийн төлбөрийг уг протез, ортопедийг хийлгэсний дараа холбогдох санхүү (протез, ортопед хийсэн эмнэлгийн байгууллага болон протезийн үйлдвэрийн төлбөрийн нэхэмжлэх)-гийн баримт болон энэ зааврын 2.3-т заасан баримт бичгийг үндэслэн Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны "Жишиг үнийн жагсаалт шинэчлэн батлах тухай" A/507, A/112 дугаар хамтарсан тушаалаар баталсан жишиг үнэ (цаашид "жишиг үнэ" гэх)-ийн хэмжээгээр олгоно.

1.3 Энэ зааврын 1.2-т заасан нэхэмжилсэн төлбөрийн дүн нь тухайн протез, ортопедийн жишиг үнээс бага бол нэхэмжилсэн үнийн дүнгээр, их бол жишиг үнийг баримтална.

1.4 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчид зөвхөн протез, ортопедийн төлбөрийг олгох бөгөөд түүнийг хийхтэй холбогдсон тусламж, үйлчилгээний зардлыг олгохгүй.

1.5 Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчид олгосон протез, ортопедийн зардлын тайланг сар бүр гаргана.

Хоёр. Монгол Улсад хийлгэсэн протез,
ортопедийн төлбөр олгох

2.1 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 30 ба түүнээс дээш хувиар алдсан даатгуулагчийн Монгол Улсад хийлгэсэн протез, ортопедийн эхний удаагийн үнийг 100 хувь, даатгуулагч албан журмаар даатгуулан нийгмийн даатгалын шимтгэл үргэлжлүүлэн төлж байгаа бол протез, ортопедийн эдэлгээний хугацаа дууссан тохиолдол бүрт,



НДЕГ "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ /протез, ортопед/-ний төлбөр олгоход баримтлах заавар"

түүнчлэн энэ зааврын 2.3.5-д заасан шийдвэр, дүгнэлтийн дагуу протез, ортопедийг дахин хийсэн бол тухай бүрт үнийг 100 хувь буюу бүрэн, харин нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй бол хоёр дахь удаад үнийн 50 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгоно.

2.2 Протез, ортопедийн төлбөр авах даатгуулагч оршин суугаа газрын харьяа нийгмийн даатгалын хэлтэст энэ зааврын 2.3.4-т заасан нэхэмжлэх бичигдсэн өдрөөс хойш 4 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай байсан бол 6 сарын дотор хүсэлтээ гаргана.

2.3 Протез, ортопедийн төлбөр авахыг хүссэн даатгуулагч хүсэлтээ доор дурдсан баримт бичгийн хамт оршин суугаа газрын харьяа нийгмийн даатгалын хэлтэст биеэр эсхүл цахимаар ирүүлнэ:

2.3.1 Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэсэн акт эсхүл үйлдвэрлэлийн ослыг нөхөн тогтоосон шүүхийн шийдвэрийн хуулбар;

2.3.2 Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актын хуулбар;

2.3.3 Даатгуулагчид протез, ортопед хийх шаардлагатай талаарх эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын шийдвэр эсхүл Гэмтэл согог судлалын үндэсний төв зэрэг төрөлжсэн мэргэшлийн эмнэлэг (цаашид "мэргэшлийн эмнэлэг" гэх)-ийн эмч нарын зөвлөгөөний шийдвэр, дүгнэлт;

2.3.4 Протез, ортопед хийлгэсэн эмнэлгийн байгууллага болон протезийн үйлдвэрээс ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэх төгрөг (харилцагч банкны нэр, дансны дугаар, нэхэмжилсэн төлбөрийн дүн)-өөр;

2.3.5 Протез, ортопедийн эдэлгээний хугацаа дуусаагүй боловч зайлшгүй шалтгаан (холгох, нухах, эвдрэл, гэмтэл зэрэг)-аар дахин хийлгэх шаардлагатай бол энэ талаарх мэргэшлийн эмнэлгийн эмч нарын зөвлөгөөний шийдвэр, дүгнэлт;


2.3.6 Хүндэтгэн үзэх шалтгаантай байсныг нотлох баримт бичиг.

2.4 Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч нь даатгуулагчийн баримт бичгийг хүлээн авч үндэслэл, бүрдлийг шалгаж шаардлага хангасан хүсэлтийг Санхүү бүртгэлийн тасагт шилжүүлснээр протез, ортопедийн төлбөрийг тухайн эмнэлгийн байгууллага болон протезийн үйлдвэрээс ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэхийн дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас бэлэн бусаар шилжүүлнэ.

2.5 Даатгуулагчийн Монгол Улсад хийлгэсэн протез, ортопедийн 2 дахь удаагийн төлбөрийг олгохдоо энэ зааврын 1, 2 дахь хэсэгт заасныг баримтална.

2.6 Энэ зааврын 2.3-т заасан баримт бичгийг цахимаар бүрдүүлж болно.

Гурав. Гадаад улсад хийлгэсэн протез-
ортопедийн төлбөр олгох





НДЕГ “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ /протез, ортопед/-ний төлбөр олгоход баримтлах заавар”

3.1 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан, зайлшгүй шаардлагаар мэргэшлийн эмнэлгийн дүгнэлтийн дагуу гадаад улсад хийлгэх протез, ортопедийн төлбөрийг даатгуулагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас нэг удаа олгоно.

3.2 Мэргэшлийн эмнэлгийн эмч нарын зөвлөгөөн нь даатгуулагчид протез, ортопедийг гадаад улсад хийлгэх шаардлага, үндэслэлийг тогтоож дүгнэлт гаргах бөгөөд зөвлөгөөний протокол, дүгнэлтийг даатгуулагчийн хүсэлтийн хамт Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах төв комисс (цаашид “комисс” гэх)-т ирүүлнэ.

3.3 Комисс нь энэхүү зааврын 3.2-т заасан дүгнэлт болон холбогдох баримт бичгийг судлан, тухайн даатгуулагчийн протез, ортопедийг гадаад улсад хийлгэх талаар дүгнэлт гаргана.

3.4 Комисс нь даатгуулагчийн үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэсэн акт, мэргэжлээс шалтгаалсан өвчний тодорхойлолт болон тухайн даатгуулагчийг хүлээн авч протез, ортопедийг хийх гадаад улсын эмнэлгийн байгууллагаас ирүүлсэн протез, ортопедийн төлбөрийн нэхэмжлэл /харилцагч банкны нэр, дансны дугаар/-ийг хянан бүрдүүлнэ.

3.5 Гадаад улсад хийлгэсэн протез, ортопедийн төлбөрийг энэ зааврын 2.2-т заасан хугацаанд мөн зааврын 2.3-т заасан баримт бичгийг бүрдүүлснээр комиссын зөвшөөрлийг үндэслэн тухайн даатгуулагчийн оршин суугаа газрын харьяа нийгмийн даатгалын хэлтэс үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тухайн гадаадын эмнэлгийн байгууллагад энэ зааврын 1.3-т заасныг баримтлан бэлэн бусаар шилжүүлнэ.

3.6 Хэрэв даатгуулагч гадаад улсад протез, ортопедийг өөрийн зардлаар хийлгэсэн бол түүнд протез, ортопедийн төлбөрийг олгох асуудлыг энэ зааврын 2.2, 3.1-3.5-д заасныг баримтлан шийдвэрлэнэ.

Дөрөв. Хяналт

4.1 Энэ зааврын хэрэгжилт болон сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа байдалд эрх бүхий байгууллага болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газар, Хяналт, шалгалтын газар, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс тус тус хяналт тавьж ажиллана.

Тав. Хариуцлага

5.1 Энэ зааврыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

